



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв”
ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2024/005-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2024 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Б.Азантунгалаг Утас: 92091017 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	7

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж Ахуй Нэгжийн Орлогын Албан Татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.21 № 149
танай _____-ны № _____-т

“ЭРДЭНЭМАНДАЛ ШИЛМЭЛ СҮРГИЙН
ҮРЖЛИЙН ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА М.БАТСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас “Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ материаллаг ба өргөн тархсан тул сөрөг дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд эргэлтийн сүргийн мал амьтан дансанд бүртгэлтэй байсан 90,220.0 мянган төгрөгийн 363 толгой малыг зүй бусаар хорогдсон гэж нотлох анхан шатны баримтгүй данснаас хассан;
2. Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2024 оны 04 сарын 19-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын татан буугдах шийдвэр гарсан боловч татан буулгах арга хэмжээг аваагүй, дуусгалтын балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлээгүй, татварын байгууллагаас авах 607.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5, Компанийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх зүйлд нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, толилуулга, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2024 оны 04 сарын 19-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын татан буугдах шийдвэр гарсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	628,574.98	18,750.57
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	607,263.86
1.1.6	Бараа материал	96,921,600	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,550,174.98	626,014.43
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	-
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	97,550,174.98	626,014.43
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг	611,760.55	
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	611,760.55	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	611,760.55	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(12,031,585.57)	(108,343,985.57)
2.3.11	Эздийн өмчийн дүн	108,970,000	108,970,000
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	97,550,174.98	626,014.43

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Д/д	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	30,068,000.00
02	Борлуулалтын өртөг	-
03	Нийт ашиг (алдагдал)	30,068,000.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	126,380,400.00
12	Бусад зардал	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(96,312,400.00)
19	Орлогын татварын зардал	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	
22	Тайлант үеийн ашиг (алдагдал)	(96,312,400.00)
24	Орлогын нийт дүн	

/төгрөгөөр/

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	108,970,000.00	(12,031,585.57)	96,938,414.43
2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-		(96,312,400.00)	(96,312,400.00)
3	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	108,970,000.00	(108,343,985.57)	626,014.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	24,410,000.00	13,238,000.00
1.1	Мөнгөн орлогын дүн	23,680,000.00	13,238,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн	26,577,585.52	13,851,124.41
1.2.1	Ажиллагчдад төлсөн	19,254,693.00	7,819,024.41
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,329,800.00	825,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,748,700.00	760,300.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	742,500.00	
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,501,892.52	4,446,800.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
2.2	Мөнгөн зарлагын дүн		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,167,585.52)	(613,124.41)
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	2,796,160.50	628,574.98
7	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	628,574.98	18,750.57

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй.

Залруулагдаагүй 90220.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрлээ. Тайлант хугацаанд эргэлтийн сүргийн мал амьтан дансанд бүртгэлтэй 363 толгой 90,220.0 мянган төгрөгийн мал зүй бусаар хорогдсон гэж данс бүртгэлээс хассан байх бөгөөд малын эмчийн тодорхойлолт, хорогдсон малын дэлгэрэнгүй бүртгэл жагсаалтгүй, хорогдсон мал нь байгууллагын эзэмшилд байсан бүртгэлтэй мал мөн болохыг нотлох хангалттай, зохистой баримтгүй байна. Өмнөх аудитаар байгууллагын эзэмшилд байгаа 96,800.0 мянган төгрөгийн 468 толгой малыг бодитоор оршин байгааг нотлох эзэмгний дугаар, нас, хүйс, зүсээр бүртгэсэн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж фото зургаар баримтжуулан эргэж шалгуулах, буруутай этгээдэд хариуцлага тооцох А0371160/360 дугаартай албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй бөгөөд энэ онд зүй бусаар хорогдсоноор тайлагнасан нь төрийн өмч хөрөнгийг шамшигдуулсан байж болзошгүй гэмт хэргийн шинжтэй байх тул хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 2 зөрчилтэй асуудал нь 90,220.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 195.4 мянган төгрөгөөс их бөгөөд уг зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

5.2.1. Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2024 оны 04 сарын 19-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Эрдэнэмандал сумын шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан боловч татан буугдах балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлээгүй татварын байгууллагаас авах 607.3 мянган төгрөгийн авлагатай, 363 толгой 90,220.0 мянган төгрөгийн мал зүй бусаар хорогдсоныг нотлох анхан шатны баримт дутуу, ТУЗ-өөс хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-өөс хяналт хэрэгжүүлэн, татан буугдах балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тайлант хугацаанд эргэлтийн сүргийн мал амьтан дансанд бүртгэлтэй 363 толгой 90,220.0 мянган төгрөгийн мал зүй бусаар хорогдсон байна	1	90,220.0								1	90,220.0
Татан буугдах шийдвэр гарсан боловч татан буугдах балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлээгүй, татварын байгууллагаас авах 607.3 мянган төгрөгийн авлагатай байна.	1	-			1	-					
Нийт дүн	1	90,220.0			1	-				1	90,220.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								